

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦСОН НАМ ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ,
ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/12-ШТА-НА-ГСА

Говьсүмбэр аймаг

2024

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа, Утас: 70543156,
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр, Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Анхтуяа, Утас: 70543179
Цахим хаяг: Ankhtuyab@audit.gov.mn
Аудитор: С.Батцэцэг, Утас: 70543179
Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Анхтуяа

Аудитор
С.Батцэцэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543179 дугаарын утсаар
харилцана уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 206 тоот

2024 оны 12 дугаар сар

1. 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 1 нам нь хуулийн хугацаанд сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг мэдэгдэж бүртгүүлээгүй, зардлын тайлангаа ирүүлээгүй байна. 7

1.1. 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 1 нам нь хуулийн хугацаанд сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг мэдэгдэж бүртгүүлээгүй, зардлын тайлангаа ирүүлээгүй байна. 7

1.2 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 2 нам нь сонгуулийн үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулаагүй байна.8

2. Ээлжит сонгуульд оролцсон 41 нэр дэвшигч хуулиар зөвшөөрөөгүй хандивыг буцаан шилжүүлээгүй, улсын орлого болгоогүй, сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.9

2.1 Хуулиар зөвшөөрөөгүй нийт 10,706.0 мянган төгрөгийн хандивыг 41 нэр дэвшигч буцаан шилжүүлээгүй, улсын орлого болгоогүй байна.9

2.2 14 нэр дэвшигчээс нийт 45 ухуулагч иргэнд олгосон урамшууллаас 1,324.2 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутгаагүй, суутгасан боловч холбогдох байгууллагын дансанд шилжүүлээгүй байна.10

Дүгнэлт

Зөвлөмж

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлан баталгаажуулах тушаал

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх:

Аудитыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2-д заасан орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Аймаг, сумын 2024 оны ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив хуульд нийцсэн эсэх, сонгуулийн зардлыг хуулийн дагуу зарцуулсан эсэхийг хянаж, дүгнэлт, зөвлөмж гарган дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлэхэд чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Орон нутгийн ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл нь сонгуулийн зардлын санхүүжилтийг хуульд заасан шаардлагын дагуу хүлээн авч, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан эсэх
- Орон нутгийн ээлжит сонгуульд нам, эвслээс болон бие даан оролцсон нэр дэвшигчид нь сонгуулийн зардлын санхүүжилтийг хуульд заасан шаардлагын дагуу хүлээн авч, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан эсэх

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
- ХХОАТ-ын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны А/14 дүгээр тушаалаар баталсан “Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох тухай”
- Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны А/20 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх танилцуулах журам”

Аудитын хамарсан
хүрээ:

Аудитад аймаг, сумын 2024 оны ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие даан нэр дэвшсэн нийт 184 нэр дэвшигчдийн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга, бусад шаардлагатай баримтуудыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг Төрийн аудитын тухай хууль, Аймаг, нийслэл сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн хүрээнд MNS 6817:2020-Төрийн аудитын стандартын дагуу боловсрууллаа.

Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа:

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2024 оны 12 дүгээр сарын 10-ны өдрөөс 12 дугаар сарын 18-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 12 дугаар сарын 20-ны дотор боловсруулан, тайланг дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага албан тушаалтанд 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хүргүүллээ.

Хүндрэл бэрхшээл:

Аудитыг гүйцэтгэхэд “2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” нийцлийн аудит, санхүүгийн тайлангийн завсар үеийн аудит давхцаж хийгдэж байгаагаас шалтгаалан хугацааны хувьд хүндрэл үүсгэлээ.

Үндсэн мэдээлэл:

Нийт 3 нам, 182 нэр дэвшигч хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулж сонгуулийн зардлын тайланг ирүүлсэн байна.

Хүснэгт товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	2024 оны ээлжит сонгуульд оролцсон намуудын хандив, орлогын нэгтгэл	7
Хүснэгт 2	2024 оны ээлжит сонгуульд оролцсон намуудын зарлагын нэгтгэл	8
Хүснэгт 3	2024 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн хандив, орлогын нэгтгэл	9
Хүснэгт 4	2024 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн зарлагын нэгтгэл	10-11

БҮЛЭГ 1

2024 оны ээлжит сонгуульд оролцсон 1 нам нь хуулийн
хугацаанд сонгуулийн зардлын дансны дугаар, банкны
нэрийг мэдэгдэж бүртгүүлээгүй, зардлын тайлангаа
ирүүлээгүй байна.

1.1. 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 1 нам нь хуулийн хугацаанд сонгуулийн зардлын
дансны дугаар, банкны нэрийг мэдэгдэж бүртгүүлээгүй, зардлын тайлангаа ирүүлээгүй
байна.

Аймаг болон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам,
эвслээс Монгол ардын нам, Ардчилсан нам, Хүн нам, Үнэн ба зөв нам нийт 4 нам оролцсон байна.
Үнэн ба зөв нам нь *Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн
тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3¹-д* заасан хуулийн хугацаанд сонгуулийн зардлын дансны
дугаар, банкны нэрийг мэдэгдэж бүртгүүлээгүй байна. Иймд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр
зүйлийн 21² дүгээр заалт, Зөрчил шалгах шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.12³-д
зааснаар Татварын газар шилжүүлэхээр шийдвэрлэв.

Монгол ардын нам, Ардчилсан нам, Хүн нам нь *Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн
төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3⁴-д* заасан хугацаанд
аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулж, зардлын тайлангаа ирүүлсэн ба Үнэн ба Зөв нам нь
огт ирүүлээгүй байна. Энэ нь Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 25⁵ дугаар заалт, Зөрчил
шалган шийдвэрлэх тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 6.22⁶-т зааснаар аймгийн Санхүү, төрийн
сангийн хэлтэст шилжүүлэхээр шийдвэрлэв.

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд оролцсон намуудаас Ардчилсан нам зардлын
тайлангаар намын хөрөнгөөр нийт 15,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, тайлагнасан байна.
Монгол Ардын нам, Хүн нам нь сонгуулийн зардлын дансанд хандив, орлого төвлөрүүлээгүй байна.
Үүнд:

Хүснэгт № 1. 2024 оны ээлжит сонгуульд оролцсон намуудын хандив, орлогын нэгтгэл
/мян.төгрөгөөр /

Нам, эвслийн нэр	Нам, эвслээс оруулсан хөрөнгө		Хуулийн этгээдийн өгсөн хандив		Иргэний өгсөн хандив		Нийт орлогын дүн
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	
Монгол Ардын нам	-	-	-	-	-	-	-
Ардчилсан нам	1	15,000.0	-	-	-	-	15,000.0
Хүн нам	-	-	-	-	-	-	-
Нийт дүн							15,000.0

¹ Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.

² Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

³ татварын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.5 дугаар зүйл, 7.10, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл, 7.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 10.6 дугаар зүйл, 11.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 11.19, 11.24 дүгээр зүйл, 14.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16.4 дүгээр зүйл, 17.1 дүгээр зүйлийн 21, 22, 24 дэх хэсэгт заасан зөрчил

⁴ Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

⁵ Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

⁶ нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.4 дүгээр зүйлийн 1, 5 дахь хэсэг, 9.8 дугаар зүйл, 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 11.1 дүгээр зүйл, 11.10 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, 11.13 дугаар зүйл, 11.18, 11.20, 11.25, 11.27 дугаар зүйл, 17.1 дүгээр зүйлийн 25, 27 дахь хэсэгт заасан зөрчил

1.2 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 2 нам нь сонгуулийн үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулаагүй байна.

2024 оны ээлжит сонгуульд оролцсон намуудаас Ардчилсан нам нь сонгуулийн үйл ажиллагаанд нийт 15,000.0 мянган төгрөгийг зарцуулснаас сонгуулийн зардалд 15,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Монгол Ардын нам, Хүн нам сонгуулийн үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулаагүй байна. Үүнд:

Хүснэгт № 2. 2024 оны ээлжит сонгуульд оролцсон намуудын зарлагын нэгтгэл

2. /мян.төгрөгөөр/	
Зардлын ангилал	Мөнгөн дүн
Нийт зардлын дүн	15,000.0
2.1 Сонгуулийн зардал	15,000.0
2.1.1 Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	9,165.0
2.1.2 Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал	-
2.1.3 Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	3,820.0
2.1.4 Сонгогчидтой уулзалт хурал цуглаан хийх зардал	-
2.1.5 Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	15.0
2.1.6 Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	-
2.1.7 Цахим орчин ашиглах зардал	2,000.0
2.1.8 Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	-
2.2 Бусад зардал	-
Эх сурвалж: Аудиторын тулган баталгаажуулалт	

Аудитаар намуудын сонгуулийн үйл ажиллагааны зардлын зарцуулалтыг шалгахад зөрчил илрээгүй байна.

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны А/14 дүгээр тушаалаар тогтоосон “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ”-г хэтрүүлээгүй байна.

БҮЛЭГ 2

Ээлжит сонгуульд оролцсон 41 нэр дэвшигч хуулиар зөвшөөрөөгүй хандивыг буцаан шилжүүлээгүй, улсын орлого болгоогүй, сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

2.1 Хуулиар зөвшөөрөөгүй нийт 10,706.0 мянган төгрөгийн хандивыг 41 нэр дэвшигч буцаан шилжүүлээгүй, улсын орлого болгоогүй байна.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон Монгол Ардын намаас 90, Ардчилсан нам 90, Хүн нам 2, Үнэн ба зөв нам 2, бие даагч 1, нийт 185 нэр дэвшигч *Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3⁷*-д заасан хуулийн хугацаанд сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг мэдэгдэж бүртгүүлсэн байна.

2024 оны ээлжит сонгуульд оролцсон Монгол Ардын нам 88, Ардчилсан нам 90, Хүн нам 2, Үнэн ба зөв нам 1, бие даагч 1 нийт 182 нэр дэвшигч *Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3⁸*-д зааснаар хуулийн хугацаанд аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулж, зардлын тайлангаа ирүүлсэн байна. Монгол ардын намын 2 нэр дэвшигч хуулийн хугацаа хоцроож зардлын тайлангаа ирүүлсэн байна.

Үнэн ба зөв намын 1 нэр дэвшигч аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулж зардлын тайлангаа ирүүлээгүй байна. Иймд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 25 дахь заалт, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.22⁹-т зааснаар аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст шилжүүлэхээр шийдвэрлэв.

Хүснэгт № 3. 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн хандив, орлогын нэгтгэл

Нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө		Нам эвслийн хөрөнгө	Хуулийн этгээдийн өгсөн хандив		Иргэний өгсөн хандив		Нийт орлогын дүн
	Тоо	Мөнгөн дүн	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	
Монгол Ардын намаас нэр дэвшигч 90	42	18,517.5	-	7	8,500.0	219	41,157.9	68,175.4
Ардчилсан намаас нэр дэвшигч 90	56	21,831.9	-	-	-	113	20,545.0	42,376.9
Хүн намаас нэр дэвшигч 2	-	-	4,500.0	-	-	6	800.0	5,300.0
Үнэн ба зөв намаас нэр дэвшигч 1	-	-	-	-	-	1	20.0	20.0
Бие даагч 1	1	0.6	-	-	-	8	780.0	780.6
Нийт дүн	99	40,350.0	4,500.0	7	8,500.0	347	63,302.9	116,652.9

Эх сурвалж: Аудиторын тулган баталгаажуулалт

2024 оны ээлжит сонгуульд оролцсон нийт 184 нэр дэвшигч зардлын тайлангаар намын хөрөнгөөр 4,500.0 мянга, өөрийн хөрөнгөөр 40,350.0 мянга, хуулийн этгээдийн өгсөн хандив 8,500.0 мянга, иргэний өгсөн хандив 63,302.9 мянга, нийт 116,652.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Аудитаар сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн хандив, орлогын эх үүсвэрийг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрсэн байна. Тухайлбал,

Хүснэгт № 4. 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивын жагсаалт

⁷ Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.

⁸ Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

⁹ нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.4 дүгээр зүйлийн 1, 5 дахь хэсэг, 9.8 дугаар зүйл, 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 11.1 дүгээр зүйл, 11.10 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, 11.13 дугаар зүйл, 11.18, 11.20, 11.25, 11.27 дугаар зүйл, 17.1 дүгээр зүйлийн 25, 27 дахь хэсэгт заасан зөрчил

Нам, эвслийн нэр	Нэр дэвшигчдийн тоо	Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивын мөнгөн дүн		Хандивлагчид буцаасан мөнгөн дүн	Буцаагаагүй хандивын мөнгөн дүн
		Тоо	Мөнгөн дүн		
Монгол Ардын нам	44	87	19,061.0	11,895.0	7,166.0
Ардчилсан нам	31	36	8,715.0	5,655.0	3,060.0
Хүн нам	1	3	250.0	0.0	250.0
Үнэн ба зөв нам	1	1	20.0	20.0	0.0
Бие даагч	1	2	230.0	0.0	230.0
Нийт	78	129	28,276.0	17,570.0	10,706.0

Эх сурвалж: Аудиторын тулган баталгаажуулалт

Нийт 78 нэр дэвшигч хууль журамд заасан шаардлага хангаагүй /нэр, регистрийн дугаар, бүртгэлийн дугаар, эх үүсвэр тодорхойгүй/ нийт 28,276.0 мянган төгрөгийн хандив хүлээн авснаас 17,570.0 мянган төгрөгийн хандивыг хандивлагч иргэдэд буцаан шилжүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.4¹⁰, 53.5¹¹-д зааснаар 41 нэр дэвшигч нь хууль журамд заасан шаардлага хангаагүй нийт 10,706.0 мянган төгрөгийн хандивыг хүлээн авсан боловч буцаан шилжүүлээгүй, улсын орлого болгоогүй, сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна. /Ардчилсан намаас 16 нэр дэвшигч нийт 3,060.0 мянга, Монгол Ардын намаас 23 нэр дэвшигч нийт 7,166.0 мянга, Хүн намаас 1 нэр дэвшигч нийт 250.0 мянга, бие даан 1 нэр дэвшигч 230 мянга/ Хавсралт №02

Иймд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21¹² заалт, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.12¹³-д зааснаар аймгийн Татварын газарт шилжүүлэхээр шийдвэрлэв.

2.2 14 нэр дэвшигчээс нийт 45 ухуулагч иргэнд олгосон урамшууллаас 1,324.2 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутгаагүй, суутгасан боловч холбогдох байгууллагын дансанд шилжүүлээгүй байна.

Ээлжит сонгуульд оролцсон нийт 184 нэр дэвшигч сонгуулийн үйл ажиллагаанд нийт 99,515.4 мянган төгрөгийг зарцуулснаас хуульд заасан сонгуулийн зардалд 98,562.9 мянга, бусад зардалд 902.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт № 4. 2024 оны ээлжилт сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн зарлагын нэгтгэл

Зардлын ангилал		Мөнгөн дүн
Нийт зардлын дүн		99,515.4
2.1 Сонгуулийн зардал		98,562.9
2.1.1 Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах		-
2.1.2 Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал		-
2.1.3 Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал		-
2.1.4 Сонгогчидтой уулзалт хурал цуглаан хийх зардал		-
2.1.5 Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал		82,362.4
2.1.6 Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах		20.0
2.1.7 Цахим орчин ашиглах зардал		8,370.0
2.1.8 Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал		7,810.5
2.2 Бусад зардал		902.4

Эх сурвалж: Аудиторын тулган баталгаажуулалт

Аудитаар сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн сонгуулийн үйл ажиллагааны зардлын зарцуулалтыг шалгахад дараах зөрчлүүд илэрсэн байна.

¹⁰ Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, иргэний бүртгэлийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ.

¹¹ Буцах хаяг нь тодорхойгүй хандивыг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын орлогод буюу төрийн санд шилжүүлнэ.

¹² Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

¹³ татварын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.5 дугаар зүйл, 7.10, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл, 7.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 10.6 дугаар зүйл, 11.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 11.19, 11.24 дүгээр зүйл, 14.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16.4 дүгээр зүйл, 17.1 дүгээр зүйлийн 21, 22, 24 дэх хэсэгт заасан зөрчил

- Нийт 11 нэр дэвшигч нь 37 ухуулагч иргэнд 11,355.1 мянган төгрөгийн урамшуулал олгосон боловч 1,072.2 мянган төгрөгийн ХХОАТ суутгаагүй, 3 нэр дэвшигч 8 ухуулагч иргэнд 2,520.0 мянган төгрөгийн урамшуулал олгож 252.0 мянган төгрөгийн ХХОАТ суутгасан боловч холбогдох байгууллагын дансанд шилжүүлээгүй /Хавсралт №03 /

Иймд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21¹⁴ дэх заалт, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.12¹⁵ дахь заалтуудын дагуу аймгийн Татварын газарт шилжүүлэхээр шийдвэрлэв.

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны А/14 дүгээр тушаалаар тогтоосон “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ”-г хэтрүүлээгүй байна.

Аудитаар нийт 12,030.2 мянган төгрөгийн зөрчил илэрч аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, аймгийн Татварын газарт нийт 4 зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

¹⁴ Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

¹⁵ татварын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.5 дугаар зүйл, 7.10, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл, 7.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 10.6 дугаар зүйл, 11.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 11.19, 11.24 дүгээр зүйл, 14.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16.4 дүгээр зүйл, 17.1 дүгээр зүйлийн 21, 22, 24 дэх хэсэгт заасан зөрчил

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 1 нам нь хуулийн хугацаанд сонгуулийн зардлын дансны дугаар бүртгүүлээгүй, зардлын тайлан ирүүлээгүй байна.
- Нийт 41 нэр дэвшигч хуулиар зөвшөөрөөгүй хандивыг буцаан шилжүүлээгүй, улсын орлого болгохгүйгээр зарцуулсан байна.
- Нийт 14 нэр дэвшигч ухуулагчид урамшуулал олгосон боловч зарим нь ХХОАТ суутгаагүй, суутгасан нь холбогдох байгууллагын дансанд шилжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтэст:

1. Сонгуулийн зардлын тайлан ирүүлээгүй 1 нам, 1 нэр дэвшигчид Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 25-д “Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6-д “Дараах эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ”, уг хуулийн 6.22-д “нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.4 дүгээр зүйлийн 1, 5 дахь хэсэг, 9.8 дугаар зүйл, 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 11.1 дүгээр зүйл, 11.10 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, 11.13 дугаар зүйл, 11.18, 11.20, 11.25, 11.27 дугаар зүйл, 17.1 дүгээр зүйлийн 25, 27 дахь хэсэгт заасан зөрчил” гэж заасан байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3¹⁶-д зааснаар зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй 1 нам, 1 нэр дэвшигчид хуульд заасан арга хэмжээг авах

Аймгийн Татварын газарт:

1. Сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүргүүлээгүй 1 намд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21-д “Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6-д “Дараах эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ”, уг хуулийн 6.12-т “татварын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.5 дугаар зүйл, 7.10, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл, 7.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 10.6 дугаар зүйл, 11.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 11.19, 11.24 дүгээр зүйл, 14.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16.4 дүгээр зүйл, 17.1 дүгээр зүйлийн 21, 22, 24 дэх хэсэгт заасан зөрчил”

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-д зааснаар сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг төрийн аудитын байгууллагад мэдэгдэж бүртгүүлээгүй 1 намд хуульд заасан арга хэмжээ тооцох

2. Нийт 41 нэр дэвшигч нь хууль журамд заасан шаардлага хангаагүй хандивыг хүлээн авч буцаан шилжүүлээгүй, улсын орлого болгоогүй, сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан /Ардчилсан намаас 16 нэр дэвшигч нийт 3,060.0 мянга, Монгол Ардын намаас 23 нэр дэвшигч нийт 7,166.0 мянга, Хүн намаас 1 нэр дэвшигч нийт 250.0 мянга, бие даан 1 нэр дэвшигч 230 мянга /
3. Нийт 11 нэр дэвшигч нь 37 ухуулагч иргэнд 11,355.1 мянган төгрөгийн урамшуулал олгосон боловч ХХОАТ суутгаагүй, 3 нэр дэвшигч 8 ухуулагч иргэнд 2,520.0 мянган

¹⁶ Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

төгрөгийн урамшуулал олгож 252.0 мянган төгрөгийн ХХОАТ суутгасан боловч холбогдох байгууллагын дансанд шилжүүлээгүй

Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21-д “Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.12-д “*татварын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.5 дугаар зүйл, 7.10, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл, 7.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 10.6 дугаар зүйл, 11.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 11.19, 11.24 дүгээр зүйл, 14.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16.4 дүгээр зүйл, 17.1 дүгээр зүйлийн 21, 22, 24 дэх хэсэгт заасан зөрчил*” гэж заасан байна.

Хуулиар зөвшөөрөөгүй нийт 10,706.0 мянган төгрөгийн хандив хүлээн авч буцаан шилжүүлээгүй, улсын орлого болгоогүй сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан 41 нэр дэвшигч ухуулагчид урамшуулал олгосон боловч нийт 1,324.2 мянган төгрөгийн ХХОАТ суутгаагүй, суутгасан боловч холбогдох байгууллагын дансанд шилжүүлээгүй 14 нэр дэвшигчид хуульд заасан арга хэмжээ тооцох

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/Бд

Чойр

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9, 18.10 дахь заалт, “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн Татварын газар, Санхүү, төрийн сангийн хэлтэст тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Б.Анхтуяа)-д даалгасугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилган, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Татварын газрын дарга, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор (Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг)-т үүрэг болгосугай.

5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг)-т даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Г.Наранбаяр)-т даалгасугай.



Б.САРАНТУЯА

D:\DOTOOD AJIL\TUSHAAL.doc

008010142

Хавсралт №01

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчид нэг
сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэний жагсаалт

№	Нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн нэр	Хандив өгсөн иргэний овог нэр	Хандивын дүн, төгрөгөөр
1	Ардчилсан нам	И.Мөнхбат	Ц.Ариунаа	1,000,000.00
2	Ардчилсан нам	И.Мөнхбат	Бат-Энх	1,000,000.00
3	Монгол Ардын нам	Ц.Энхжаргал	Д.Оюунбилэг	1,000,000.00
4	Монгол Ардын нам	Г.Эрдэнэбаатар	Г.Анхбаатар	1,000,000.00
5	Монгол Ардын нам	Т.Түмэнбаяр	Б.Энхболд	1,000,000.00
6	Монгол Ардын нам	Э.Амарсайхан	Ч.Цолмонбаатар	1,000,000.00
7	Монгол Ардын нам	Т.Бат-Эрдэнэ	Т.Тамир	1,000,000.00
8	Монгол Ардын нам	Б.Отгонсүрэн	Ц.Мөнхпүрэв	1,000,000.00
9	Монгол Ардын нам	Б.Наранбаатар	Б.Наранзул	1,000,000.00
10	Монгол Ардын нам	Г.Батзам	Х.Баярцэнгэл	1,230,000.00
11	Монгол Ардын нам	Б.Ариунболор	С.Сүйндөг	1,060,000.00
12	Монгол Ардын нам	Б.Анхбаяр	Б.Сосорбурам	1,000,000.00